



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 20 өдөр

Дугаар A/141

Бат-Өлзий сум

Г Ерөнхий боловсролын сургуулийн
Хүүхэд хамгааллын багийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.20 дахь заалт, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ерөнхий боловсролын сургуулийн “Хүүхэд хамгааллын баг”-ийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч: Ерөнхий боловсролын сургуулийн захирал

Гишүүд: Нийгмийн ажилтан

Дотуур байрын багш

Сургуулийн эмч

Ахлах ангийн сургалтын менежер

Бага ангийн сургалтын менежер

Бага ангийн багш (А.Амартувшин)

Нийгмийн ухааны багш (Ж.Доржханд)

Биеийн тамирын багш (Б.Бямбадорж)

2. Гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалах ажлын талаар төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, жил бүр тайлагнаж ажиллахыг “Хүүхэд хамгааллын баг”-ийн ахлагч (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын “Ерөнхий боловсролын сургуулийн Хүүхэд хамгааллын баг байгуулах тухай” 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/68 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

